



**“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК-ИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

*/Хугацаа: 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс
2015 оны 12 дугаар сарын 31-ний өдөр/*



НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1. Оршил

Монгол Улсын Засгийн газар Дэлхийн банктэй хамтран 2005 оноос “Малын индексжүүлсэн даатгал” төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2012 оноос үндэсний хэмжээнд буюу Монгол Улсын нийслэл, бүх аймаг, хотуудад малын эрсдэлийн даатгалын үйлчилгээг нэвтрүүлж эхэлсэн.

2014 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль батлагдсанаар малын индексжүүлсэн даатгал /цаашид “МИД” гэх/-ын тогтолцоог цаашид тогтвортой үргэлжлүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн.

Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 17, 18.1, 19.1.1 дэх зүйл заалтуудын хэрэгжилтийг ханган 2014 оны 8 дугаар сарын 28-ны өдөр Засгийн газрын 280 дугаар тогтоолоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” хаалттай хувьцаат компани үүсгэн байгуулагдсан. Ийнхүү “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь малын индексжүүлсэн даатгалын төслийн үйл ажиллагааг орон даяар үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр ажиллаж байна.


Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 48 дугаар тогтоолоор компанид давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон. Сангийн сайдын 2015 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 35 дугаар тушаалаар компанийн дүрмийг боловсронгуй болгож шинэчлэн баталсан бөгөөд Сангийн сайдын 2015 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 96 дугаар тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулж, мөрдөн ажиллаж байна. Компанийн дүрэмд эрхэм зорилго, зорилтоо тодорхойлон үйл ажиллагааны зохицуулалтаа тусган баталгаажууллаа.

2015 онд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 10 удаа хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, компанийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч, гүйцэтгэх захирлыг томилох, бизнес төлөвлөгөө батлах, үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө, худалдан авалтын төлөвлөгөө батлах зэрэг зохион байгуулалт, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлаар 33 тогтоол шийдвэр гарган тэдгээрийг хэрэгжүүлэн ажиллалаа.



1.2. Бүтэц, зохион байгуулалтын талаар

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь Давхар даатгалын газар, Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газар, Бизнес хөгжил, төслийн газар, Санхүү, удирдлагын газар гэсэн 4 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явууллаа.





ХОЁР. ДАВХАР ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

2.1. 2015 оны малын индексжүүлсэн даатгалын борлуулалт, түүний бэлтгэлийг хангах чиглэлээр:

Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 2014 оны жилийн эцсийн мал тооллогын мэдээнд үндэслэн 2015 оны борлуулалтын улиралд ашиглах нэгж малын дундаж үнэлгээг нийслэл, 21 аймгаар боловсруулан гаргаж, 330 сумдын малын төрөл тус бүрийн болон нийт малын тоог тооцоолон гаргасан.

Оролцогч даатгалын компаниудын актуарч нарт МИД-ын хураамжийн хувь хэмжээг тооцоолох аргачлалын талаар сургалт зохион байгуулж, Үндэсний статистикийн хорооноос ирүүлсэн 2014 оны жилийн эцсийн малын тоо, хорогдлын мэдээ, малчин өрх болон малтай өрхийн тоо зэрэг шаардлагатай тоон үзүүлэлт, мэдээллүүдэд суурилан тооцоолол хийлгэж, хураамжийн хувийг тооцууллаа. Оролцогч даатгагч нар санал нэгтгэйгээр 2015-2017 онуудад 2014 онд ашиглаж байсан хураамжийн хувь хэмжээг ашиглахаар тогтсон.

Оролцогч даатгагч компани болон даатгуулагч нарын хооронд байгуулагдах “Малын индексжүүлсэн даатгалын гэрээ”-ний загварыг МИД төслийн хуульч, олон улсын хуулийн зөвлөхтэй хамтран боловсруулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталлаа.

2015 оны 2 дугаар сарын 25-ны өдөр даатгалын төлөөлөгч нарт сургалт хийх МИД-ын сургагч багш нарыг бэлтгэх сургалтыг “МИГ даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-иудад зохион байгууллаа.

Даатгалын төлөөлөгч сонгон шалгаруулах, эрх олгож гэрчилгээжүүлэх сургалтыг 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрөөс 4 дүгээр сарын 15-ны өдрүүдэд нийт 21 аймаг, Улаанбаатар хотод Санхүүгийн зохицуулах хороо, Даатгагчдын холбоо, даатгалын компаниуд хамтран зохион байгуулсан. Тус сургалтаар МИД-ын тухай ойлголтууд, даатгалын төлөөлөгчийн баримтлах дүрэм, журам, МИД төслийн хэрэгжилт, түүний үр дүн, жишээ бодлого, байнга тохиолддог бэрхшээлүүд, түүнийг шийдэрлэх арга зам, 2015 онд хийгдэх үйл ажиллагаануудын талаар бэлдсэн сургалтын материалыг өгч танилцуулсан. Сургалтын үеэр тавьсан МИД-ын илтгэлийг боловсруулан даатгалын компаниудад өгсөн бөгөөд сургалтанд оролцогчдод зориулсан 2015 оны МИД-ын борлуулалтанд шинээр орох өөрчлөлтүүд, хураамжийн хувийг тусгасан “МИД-ын бүтээгдэхүүний товхимол”-ыг оролцогч бүрт хүлээлгэн өглөө. Сургалтанд оролцогчид МИД-ын болон ердийн даатгалын сургалтанд сууж, нэгдсэн 1 шалгалт өгсөн бөгөөд нийт 21 аймаг,



Улаанбаатар хотын 1805 төлөөлөгч МИД-ыг борлуулах эрхтэй болж, борлуулалт хийв.

МИД-ын босго үзүүлэлтийг Засгийн газраас тогтоож байхаар Малын индексжүүлсэн даатгалын тухай хуульд заасны дагуу тогтоолын төслийг бэлтгэн боловсруулж Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 123 тоот тогтоолоор батлуулав. Уг тогтоолоор аймаг бүрт нэгдүгээр босго үзүүлэлт нь 5 болон 6 хувь, хоёрдугаар босго үзүүлэлт нь 25 болон 30 хувь байхыг зааж өгсөн ба Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн дагуу энэхүү тогтоосон босго үзүүлэлтийг 2017 оныг дуустал мөрдөн ажиллах юм.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн чиглэлийн дагуу 2015 оны МИД-ын борлуулалтын улиралд оролцох эсэх талаарх саналыг 2014 оны МИД төсөлд оролцсон 7 даатгалын компанид хүргүүлэхэд “Номин даатгал” ХХК оролцохоос татгалзаж, “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК болон “Тэнгэр даатгал” ХХК-иуд оролцох тухай албан хүсэлтээ ирүүлсэн. Хүсэлтээ ирүүлсэн даатгалын 6 компаниас 2015 оны МИД-ын борлуулалтын төлөвлөгөөг авч нэгтгэхэд 17,230 малчин өрхийг даатгалд хамруулж 1 тэрбум 480 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлэхээр төлөвлөсөн.

2015 оны МИД-ын борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн давхар даатгалын хураамжийн хувь хэмжээг даатгагч тус бүрээр тооцоолон 2015 оны “Алдагдлыг зогсоох давхар даатгалын гэрээ”-г дээрх даатгалын компаниудтай 4 дүгээр сарын 15-ны өдөр байгуулав.

Борлуулалтын төлөвлөгөөнд үндэслэн оролцогч даатгалын компаниудын зардлаар нийт 44.0 мянган ширхэг МИД-ын баталгааг “Мөнхийн үсэг” ХХК-иар хэвлүүлж, орон нутаг, даатгалын төлөөлөгчдөд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

2015 оны борлуулалтын улиралд ашиглагдах программ хангамжийг МИД төслийн зөвлөхүүдтэй хамтран шийдвэрлэж, даатгалын төлөөлөгчдийн бүртгэл болон бусад тоон мэдээллүүдийг бэлтгэн орууллаа. Мөн программ хангамжийг туршиж орон нутагт ашиглахад гарч болзошгүй алдаа байгаа эсэхийг шалгаж, бүртгэл тооцооллын алдаагүй, хэвийн ажиллах тал дээр хяналт тавьсан.

Хураамжийн хувийн тооцоололд ашигладаг дата файлыг 2014 оны сонгосон үнэлгээ, малын тоо зэргээр шинэчлэн бэлдсэн. Мөн composed index-ийг бодож, дата файльтайгаа нэгтгэн Мастер гэрээний хураамжийн хувийг тооцоолон гаргасан. Мөн SAS-ийн системээр хэд хэдэн тооцооллыг гарган өгсөн. Үүнд: 1-1000 жилийн өгөгдлөөр II, III түвшинд ямар хэмжээний нөхөн төлбөр гарах, 1-1000 жилийн өгөгдлөөр composed index буюу MR6 гаргах, түүний дундаж болон давтамжийн тооцооллыг гаргах гэх мэт болно.



МИД-ын 2015 оны борлуулалтын улирал 4 дүгээр сарын 15-ны өдөр эхэлсэнтэй холбогдуулан даатгалын компаниудтай санал солилцсоны үндсэн дээр 2015 оны “МИД-ын алдагдал зогсоох давхар даатгалын гэрээ”-нд өөрчлөлт оруулж тухайн жилийн борлуулалтын улирлыг 7 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар болсон.

МИД-ын 2015 оны борлуулалтын улирлын хаалтын үйл ажиллагааг эхлүүлж, оролцогч даатгалын компаниудийн борлуулалтын дүн мэдээг нэгтгэн, программын дүнтэй тулгах, илэрсэн алдаа дутагдлыг засаж залруулж ажилласан. Мөн оролцогч даатгалын компаниудаас 2015 онд ашиглагдсан даатгалын баталгааны бүртгэлийг авч тулгалт хийж хянав.

МИД-ын 2015 оны борлуулалтын улирал дууссантай холбогдуулан оролцогч даатгалын компаниудын борлуулалтын багцыг гаргаж, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн давхар даатгалын хураамжийн хэмжээ болон Хамтын эрсдэлийн сангийн хэмжээг тооцоолон гаргасан.

2013-2014 оны борлуулалтын ашиглаагүй 16259, хүчингүй болсон 3250 баталгааг шалгаж устгасан.

2013-2014 оны борлуулалтын улиралд дахин даатгуулсан малчдын мэдээг тооцон гаргав. 2013 оны борлуулалтын улиралд даатгуулсан 19447 малчдын мэдээг 2014 онд даатгуулсан 14445 малчинтай харьцуулахад давхардаж даатгуулсан нийт 5981 малчин байсан нь 2014 онд даатгуулсан малчдын 42.7 хувийг эзэлж байна. Уг тоон мэдээг аймаг тус бүрээр харвал хамгийн өндөр нь 55.98 хувийн дахин даатгуулсан малчидтай Баянхонгор аймаг, 54.11 хувьтай Увс аймаг, 56.40 хувьтай Дорноговь аймаг тэргүүлж байсан бол Өвөрхангай, Хөвсгөл, Төв аймгийн малчид 23-28 хувьтай дахин даатгуулсан байна.

2.2. МИД-ын эрх зүйн орчныг бүрдүүлэх, бүтээгдэхүүнийг сайжруулах чиглэлээр:

МИД-ын эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтарсан “Хамтын эрсдэлийн сангийн журам” болон “МИД-ын хураамжийн журам”-ыг боловсруулан батлуулахад шаардлагатай тоон мэдээлэл болон оролцогч талуудын саналыг нэгтгэн Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж хамтран ажиллалаа.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 78/90 дугаар тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”, 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 91/110 тоот тушаалаар “Малын индексжүүлсэн даатгалын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”-ыг тус тус батлууллаа.



Дунд болон дээд түвшин, алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журмын төслийг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох ажилтнуудтай хамтран боловсруулж дууссан.

МИД-ын нөхөн төлбөр олгох журмын төслийг боловсруулан бэлэн болгосон ба энэхүү журам нь Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд нарын хамтран батлах “Давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журам”-ийн хүрээнд мөрдөгдөх тул уг журам батлагдахаар Гүйцэтгэх захирлын тушаалаар эцэслэн батлахад бэлэн болсон.

“Давхар даатгалын компанийн санг бүрдүүлэх, байршуулах, зарцуулах журам”-ыг 9 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын газрын дарга, ахлах хянан шалгагч нартай хамтран боловсруулж бэлэн болголоо.

Оролцогч даатгагч нараас ирүүлсэн саналд үндэслэн МИД-ын нөхөн төлбөрийн доод хэмжээг 20 хувь байсныг өөрчилж малчны төлсөн хураамжийн 35 хувь буюу цэвэр хураамжийн 50 хувиар тооцон олгож байхаар тогтов. Даатгалын тохиолдол үүсэх үед олгох нөхөн төлбөрийн доод хэмжээ нь хэт бага байдлыг зассан.

Өнгөрсөн жилүүдэд МИД-ын төслийн нэгжтэй хамтран ажиллаж ирсэн ХААН банк болон Төрийн банктай МИД-ын чиглэлээр хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэх хүсэлт тавьсны үндсэн дээр МИД-д хамрагдсан малчдад малчны зээлийн хөнгөлөлт үзүүлэх болон МИД-ын хураамжийн зээл олгох зорилготой “Хамтын ажиллагааны гэрээ”-г байгуулсан.

Хамтран ажиллагч банкуудаас хураамжийн болон хөнгөлөлттэй зээлийн мэдээг авч нэгтгэн гаргалаа. Төрийн банк 2015 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хураамжийн зээлийг өгсөн ба 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл Баянхонгор, Хөвсгөл, Өмнөговь, Сүхбаатар, Завхан аймгийн нийт 22 малчинд 77,900,000 /далан долоон сая есөн зуун мянга/ төгрөгийн зээлийг олгосон байна. ХААН банк 2015 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл Архангай, Булган, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн 11 малчинд 3,574,150 /гурван сая таван зуун далан дөрвөн мянга нэг зуун тавин/ төгрөгийн хураамжийн зээл олгосон байна.

Мөн 2015 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 30-ны өдөр хүртэл 317 малчинд 1,439,258,250 /нэг тэрбум дөрвөн зуун гучин есөн сая хоёр зуун тавин найман мянга хоёр зуун тавин/ төгрөгийн малчны хөнгөлөлттэй зээлийг олгосон байна.

МИД-ын борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор арилжааны банкийг МИД-ын зуучлагчаар ажиллуулах судалгааг хийж, хөдөө орон нутагт хамгийн олон



салбар нэгж бүхий ХААН банк, Төрийн банктай хамтран ажиллах хүсэлт тавьсан бөгөөд ХААН банкны зүгээс 2015 онд зуучлагчаар ажиллахаас татгалзсан.

МИД-ын бүтээгдэхүүнийг цаашид арилжааны банкаар дамжуулан борлуулах асуудлаар ХААН банкны холбогдох албан тушаалтнуудтай 7 дугаар сарын 28, 8 дугаар сарын 31-ний өдрүүдэд 2 удаа уулзалт зохион байгуулж, МИД-ын зуучлагчаар ажиллах саналыг дахин тавьж, санал солилцлоо. ХААН банкны зүгээс одоогоор МИД-ын бүтээгдэхүүний судалгааг хийж байгаа бөгөөд МИД-ын бүтээгдэхүүнийг зуучлах хамтын ажиллагааны гэрээ байгуулах хүсэлтэй байгаагаа илэрхийлээд байна.

Төрийн банкинд МИД-ын зуучлагчаар ажиллах саналыг тавьсан ба байгууллага хариуцсан мэргэжилтэнтэй нь уулзалт зохион байгуулж, албан тоотоор хамтран ажиллах саналаа хүргүүлсэн. Төрийн банкны зүгээс давхардуулан даатгасан малчдын хураамжийг буцаах боломжгүй, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийг арилжааны банкны МИД-ын программд оруулсан бүртгэл хүчингүй болох, хөөн хэлэлцэх хугацааг 14 хоног болгох тухай гэсэн асуудал банкинд нааштайгаар шийдэгдвэл МИД-ийн бүтээгдэхүүнийг борлуулахад хамтран ажиллах боломжтой гэсэн хариу өгсөн байна.

Төрийн банкны тавьсан хүсэлтийн дагуу МИД-ын зуучлагчаар ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулж, Давхар даатгалын газрын дарга болон Гүйцэтгэх захирлын орлогчоор хянуулав. Уг журмыг оролцогч даатгагчдын МИД хариуцсан мэргэжилтнүүдэд явуулж санал авч бэлэн болгосон.

Хөдөө орон нутагт орон тооны ба орон тооны бус ажилтан ажиллуулах, олон улсын хандивлагч байгууллагын тусламжтайгаар тэдгээр ажилтнуудыг санхүүжүүлэх боломжийг судалж, үйл ажиллагааны зардлыг тооцон гаргаж компанийн удирдлагуудад танилцуулан тухайн судалгаан дээр үндэслэн танилцуулга бэлтгэн Дэлхийн банкны төлөөлөл болон Швейцарийн хөгжлийн агентлагтай тус тус уулзалт хийсэн. Хөдөө орон нутагт салбар байгуулах тухай танилцуулгыг англи хэл дээр бэлтгэсэн.

2.3. 2015 оны МИД-ын борлуулалтыг эрчимжүүлэх чиглэлээр:

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн зүгээс МИД-ын борлуулалтын үйл ажиллагаанд орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн сайд 2015 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 8-1/3006 тоот, Хүнс Хөдөө Аж Ахуйн сайд 2015 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн 01/1627 тоот албан бичгийг тус тус аймгийн Засаг дарга нарт хүргүүлэв. Албан бичигт орон нутагт МИД-ын борлуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх, Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах талаарх чиглэлийг тусгасан.



2015 оны МИД-ын борлуулалт болон компанийн үйл ажиллагааг орон нутагтай холбох, идэвхжүүлэх зорилгоор ажилтнуудад орон нутгийг бүс, аймгаар хуваарилан өгч орон нутгийн удирдлага болон даатгалын компанийн төлөөлөгчидтэй холбогдон МИД-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлж, мэдээлэл, арга зүйгээр хангасан.

2015 оны МИД-ын борлуулалтын мэдээг 14 хоног тутам даатгалын компанийн салбаруудаас авч нэгтгэн холбогдох талуудад хүргүүлж, даатгалд хамрагдах 9100-0770, 9807-0770 утсаар МИД-д хамрагдах хүсэлтэй малчдаас дуудлага хүлээн авч тухайн аймаг, сумын даатгалын төлөөлөгчидтэй холбосон.

Компанийн ажилтнууд хариуцсан аймаг, сумдынхаа Мал эмнэлэг үржлийн тасгийн МИД хариуцсан мэргэжилтнүүд, даатгалын компанийн аймаг дахь салбар болон даатгалын төлөөлөгчидтэй утсаар холбогдож, борлуулалтын төлөвлөгөө, түүний биелэлтийн явц, МИД-ын хураамжийн зээл, борлуулалтад нөлөөлж байгаа шалтгааны талаар асууж, зөвлөгөө өгч, арилжааны банкуудаас өгч буй малчны зээлийн хөнгөлөлт, хураамжийн зээлийн тал дээр гарч буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх арга хэмжээ авсан.

МИД-ыг борлуулж байгаа даатгалын төлөөлөгчдийг идэвхжүүлж урамшуулах, туршлага солилцуулах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор 2015 онд борлуулалт хийх эрх авсан нийт 1805 даатгалын төлөөлөгчдийн дунд болзолт уралдаан зарлаж, холбогдох мэдээллийг даатгалын компани, төлөөлөгчдөд хүргүүлэн, дүгнэж ажиллалаа. 2015 оны Улсын манлай даатгалын төлөөлөгч нэгийг, Аймгийн тэргүүний даатгалын төлөөлөгч 18-ийг шалгаруулан шагнаж урамшууллаа. Улсын манлай, Аймгийн тэргүүний даатгалын төлөөлөгч тус бүр өргөмжлөл мөнгөн шагналыг даатгалын компанийн аймаг дахь салбараар нь дамжуулан хүргүүлж гардуулсан.

Даатгалын компанийн МИД хариуцсан ажилтан, даатгалын төлөөлөгч, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн МИД хариуцсан ажилтнуудын борлуулалтын явц дахь мэргэжлийн алдаа, хайхрамжгүй, санаатай бус үйлдлийн улмаас даатгуулагч малчинд учирч блзошгүй хохирлыг бууруулах зорилготой хариуцлагын даатгалын үнийн саналыг 5 компани руу явуулж, хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Мандал даатгал” ХХК-ийг сонгон хариуцлагын даатгалыг хийлгэлээ. Энэхүү гэрээгээр 1455 ажилтан хамгаалагдаж байна.

Цөөн малтай малчин өрхүүдийн малыг даатгалд хамруулах зорилгоор нэмэгдэл хураамж олгоход шаардлагатай тооцооллуудыг хийж танилцуулан, талуудыг холбон гэрээ байгуулах ажлыг зохион байгуулав. Мөн үүнтэй холбогдуулан борлуулалтын бүртгэлийг хэрхэн хөтлөх, хураамж хэрхэн тооцох талаар зааварчилгааг даатгалын компани, салбар, төлөөлөгчдөд хүргэсэн.



МИД-ын Төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран хөдөө орон нутагт МИД-ын талаар сурталчлан таниулах, ач холбогдлыг малчдад ойлгуулах зорилгоор 19 аймгийн төсөл хэрэгжүүлэх нэгжийн аймаг дахь салбарын хуучин ажилчдыг 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд түр гэрээлэн сумдаар ажиллуулсан.

Малчдад МИД-ын төсөл хэрэгжүүлэх нэгж болон “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг хүргэх зорилгоор Төсөл хэрэгжүүлэх нэгжээс доорх сурталчилгааны хэвлэх материалуудыг оролцогч даатгалын компаниудаар дамжуулан малчдад хүргэлээ.

- Малын даатгалын сонин /120 000 ширхэг/;
- 2014 онд МИД-д хамрагдсан малчдад өгөх цаг тооны бичиг;
- “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК болон МИД-ын Төсөл хэрэгжүүлэх нэгжийн талаар малчдад зориулсан товхимол;
- Телевиз болон радио шторк /МИД-ын борлуулалтын улирлын талаар/;

МИД төслөөс 2015 оны 9 дүгээр сарын 04-ний өдөр семинар зохион байгуулж орон нутагт ажилласан сургагч багш нарын тайлан хэрэгжилт болон борлуулалтын явцад гарсан хүндрэлтэй асуудлын талаар санал солилцов.

2.4. 2014 онд МИД-д малаа даатгуулсан малчдад нөхөн төлбөр олгох, оролцогч даатгалын компаниудад ашиг хуваарилах чиглэлээр:

Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулж, гаргасан 2015 оны хагас жилийн мал тооллогын дүн, албан ёсны хорогдлын мэдээнд үндэслэн 2014 онд МИД-д хамрагдсан 14331 малчин өрхийн нөхөн төлбөрийн тооцооллыг хийж, 7 аймгийн 12 сумын нийт 1291 малчдад **62,846,217 /жаран хоёр сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун арван долоон/** төгрөгийг олгосон байна. Даатгалын компаниудад нөхөн төлбөр авах малчдын мэдээ болон нөхөн төлбөр олгох удирдамжийг явуулсан. Мөн Малын даатгалын нөхөн төлбөрийн данснаас хуваарилах ашиг болон баталгаат нөөцийн данснаас хуваарилах ашгийн хэмжээг даатгалын компани тус бүрт нь танилцуулж даатгалын компанийн дансанд шилжүүлсэн.

Төслийн удирдах хорооны шийдвэрийн дагуу МИД-ын 2014 оны Хамтын эрсдэлийн сангаас үлдсэн нийт 624,821,459 /зургаан зуун хорин дөрвөн сая найман зуун хорин нэгэн мянга дөрвөн зуун тавин есөн/ төгрөгийг /хүүгийн орлогын хамт/ 2014 оны МИД-ын борлуулалтын улиралд оролцсон даатгалын компаниудад өгөөж хэлбэрээр хуваарилсан.

2.5. Орон нутагт хүрч ажиллах чиглэлээр:

Орон нутгийн удирдлагууд, малчид, мал бүхий иргэдэд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааг сурталчлах, 2015 оны МИД-ын борлуулалтын үйл ажиллагаатай танилцах, идэвхжүүлэх, оролцогч даатгалын компаниудын салбарууд, даатгалын төлөөлөгчдийн МИД-ын борлуулалтын ажлын



явцтай танилцах, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах зорилгоор Гүйцэтгэх захирлын орлогч Б.Даажамбаар ахлуулсан 6 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 19-ний өдрүүдэд Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл, Булган, Орхон аймгуудад ажиллалаа. Ажиллах хугацаандаа даатгалын компаниудын салбарын захирал, даатгалын төлөөлөгчид, аймаг, сумдын засаг дарга, орлогч дарга нар болон малчидтай уулзалт зохион байгуулж МИД-ын явц, тулгарч буй бэрхшээл хүндрэл зэрэг асуудлуудтай танилцан, зөвлөгөө өгч мэдээлэл болон ойлголцлын зөрүүг тогтоон арилгах арга хэмжээ авлаа.

2015 оны 4 дүгээр сард Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад гарсан түймрийн улмаас бий болсон нөхцөл байдал, эдгээр аймгуудын МИД-ын үйл ажиллагаатай танилцах зорилгоор компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Н.Баяртсайхан 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдрөөс 21-ний өдрүүдэд албан томилолтоор ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн бөгөөд дэд дарга Э.Батболд 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 14-ний өдрүүдэд Баянхонгор аймагт зохион байгуулагдсан “1000 малчны өдөрлөг”, “МИД-ын зөвлөгөөн”-д оролцож, МИД-ын оролцогч даатгалын компанийн салбар нэгжийн удирдлагууд болон даатгалын төлөөлөгчидтэй санал бодлоо солилцож, зөвлөгөө өгсөн.

Гүйцэтгэх захирал Г.Энхтайван 6 дугаар сарын 30-ны өдрөөс 7 дугаар сарын 06-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт, Давхар даатгалын газрын дарга Т.Оюунбат 6 дугаар сарын 23-ны өдрөөс 26-ны өдрүүдэд Дундговь аймагт, МИД-ын төслийн ажилтан Ц.Мандах-Эрдэнэ 6 дугаар сарын 21-ний өдрөөс 23-ны өдрүүдэд Хэнтий аймагт тус тус албан томилолтоор ажиллав.

Борлуулалтыг эрчимжүүлэх, компанийн үйл ажиллагааг сурталчлах зорилгоор компанийн ажилтнууд 7 дугаар сарын 01-ний өдрөөс 7 дугаар сарын 05-ны өдрүүдэд Хөвсгөл аймагт, үр тарианы даатгалын бүтээгдэхүүн бий болгохтой холбоотойгоор мэдээлэл цуглуулахаар 9 дүгээр сарын 01, 02-ны өдрүүдэд Сэлэнгэ, Дархан-Уул аймагт, нөхөн төлбөрийг сурталчлах, телевизийн нэвтрүүлэг бэлтгэх зорилгоор 9 дүгээр сарын 23, 24-ны өдрүүдэд Архангай аймагт тус тус албан томилолтоор ажиллалаа.

Хөдөө орон нутагт МИД болон компанийн үйл ажиллагааг хариуцан тогтвортой хэрэгжүүлэх тогтолцоог хэрхэн бий болгох талаарх судалгааг эхлүүлэх зорилгоор МИД төслийн зарим орон нутгийн зохицуулагч нартай уулзаж туршлага судалсан.

2.6. Олон улсын давхар даатгалд даатгуулах чиглэлээр:

Компанийн гүйцэтгэх захирлын орлогч Б.Даажамба Сингапур улсад албан томилолтоор ажиллаж “SwissRe”, “Canopus Asia” зэрэг олон улсын давхар даатгагч нарын удирдлагуудтай уулзаж хоёр байгууллагын хамтын ажиллагааг



эхлүүлэх, давхар даатгалын үйл ажиллагааны чиглэлээр туршлага солилцох зэрэг асуудлаар удирдлагын түвшинд санал солилцсон.

МИД-ын эрсдэлийн дунд болон дээд түвшиний тодорхой хэсгийг олон улсын давхар даатгалд хамруулах хэмжээг тооцоолон гаргаж, үнийн саналыг дараах байдлаар авсан.

- Эрсдэлийн дунд түвшиний хүрээнд QatarRe, SCOR, болон Allianz олон улсын давхар даатгагч компаниудаас нийт хураамжийн 50% давсан 130% болон 55% давсан 125%.
- Эрсдэлийн дээд түвшиний хүрээнд SwissRe, Paris Liberty Syndicate, Allianz, Canopus Asia Syndicate компаниудаас нийт сонгосон үнэлгээний 0.3% давсан 3.41%-ийн эрсдэл дээр үнийн санал авахаар тогтлоо.

Оролцогч даатгалын компаниудын ирүүлсэн борлуулалтын төлөвлөгөөний дагуу 2015 оны МИД-ын нийт хураамжийн хэмжээг 1.48 тэрбум төгрөг буюу 800.0 мянган (1\$=1920₮) ам.долларт хүрнэ гэсэн урьдчилсан тооцоолол гарсан. МИД-ын эрсдэлийн дунд түвшинд нийт үнийн санал авах хэмжээг нийт даатгалын хураамжийн 50% давсан 130% болон 45% давсан 135% гэсэн 2 түвшинд авахаар тооцоолж QatarRe, “Allianz SE”, “SCOR” зэрэг давхар даатгалын компаниуд руу үнийн санал ирүүлэх албан захиаг бэлтгэн хүргүүлсэн. Давхар даатгагч нараас ирүүлсэн үнийн саналуудыг оролцогч даатгалын компаниудад танилцуулсны үр дүнд QatarRe /60%/ болон SCOR /40%/ давхар даатгагч нартай МИД-ын 2015 оны алдагдал зогсоох давхар даатгалын гэрээг нийт даатгалын хураамжийн 50% давсан 130% хэмжээтэйгээр байгуулсан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 02/28 тоот тогтоолоор МИД-ын эрсдэлийн дунд түвшиний даатгалын тэргүүлэгч давхар даатгагчаар “Катар рэ” /Qatar Re/ компанийг, дагалдуулан “СКОР” /SKOR/ компанийг, дээд түвшиний даатгалын давхар даатгагчаар “Кэнеүпиус Эшиа” /Canopus Asia/ компанийг тус тус сонгон давхар даатгалын гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын дагуу эрсдэлийн дээд түвшиний давхар даатгалын гэрээг Canopus Asia давхар даатгагчтай байгуулж, гэрээний хүрээнд **81,801,544.79 /наян нэгэн сая найман зуун нэг мянга таван зуун дөчин дөрвөн төгрөг далан есөн мөнгө/** төгрөгийн хураамж төлөн **945,570,399.17 /есөн зуун дөчин таван сая таван зуун далан мянга гурван зуун ерэн есөн төгрөг арван долоон мөнгө/** хүртэл төгрөгийн хариуцлагыг шилжүүллээ.

2.7. МИД-ын программ хангамжийн чиглэлээр:

МИД-ын онлайн программыг 2015 оны 7 дугаар сарын 01-ний өдөр нээлттэй байршуулсан ба оролцогч зургаан даатгалын компанид нэвтрэх эрх болон гарын



авлагыг хүргүүлсэн. Орон нутгийн салбаруудаар программын баазад орсон төлөөлөгчийн нэрсийг шалгуулж дутуу нэрсийг орууллаа.

Орон нутгийн салбаруудын эрхийг нээхдээ устгах эрхийг дутуу нээсэн, хуудас олгоход гарч байсан техник алдаа, малчдын регистрийн алдаатай бүртгэл, даатгуулсан огноо буруу оруулсан, малын тоог буруу оруулсан бүртгэл, давхардаж даатгуулсан малчдын мэдээлэл, тайлан гаргахад нийт тоо болон баганын дүн буруу гарч байсан зэрэг программд гарч байсан алдааг засуулсан.

Хуудасны жагсаалт, борлуулалтын жагсаалт, орлогын жагсаалтыг эксел файл руу хөрвүүлдэг болгох, борлуулалтын жагсаалтанд МЭД-ын дүн, нийт хураамж, даатгалын компанийн үйл ажиллагааны зардлын дүн, хөнгөлөлтийн дүнгийн нийт дүнг доод мөрөнд харуулдаг болгох, 3000-аас дээш тооны малаа даатгуулсан малчдын малын тоог шалгах, бод малын тоо 300-аас дээш даатгасан малын тоог шалгах зэрэг тохируулгыг хийлээ.

Оролцогч даатгалын компанийн салбаруудад утсаар МИД-ын программ ашиглахад гарсан алдаа, хүндрэлийн талаар тайлбарлаж зөвлөгөө өгсөн.

МИД-ын 2015 оны үндсэн программд хураамжийн орлогын жагсаалт /төлөөлөгчөөр/ цонхыг боловсруулах, борлуулалтын харьцуулалт цонх болон даатгалын компанийн мэдээллийг үндсэн сан руу шилжүүлэх хэсгийг хийх, МИД-ын 2015 оны үндсэн программд тохируулгын гүйлгээ хийх болон гүйлгээний лавлагаа авах цонхыг боловсруулах, МИД-ын 2015 оны үндсэн программд тайлангийн хэсгүүдийг боловсруулах зэрэг ажлуудыг дуусгасан. Үүнд: Даатгалын компани, төлөөлөгч, аймаг, сум, компани аймаг зэрэг тайлангуудыг боловсруулсан. Тайланг авахдаа аль баазаас гаргах аа сонгох боломжтой болгосон.

Вэб программд шинээр тайлангууд нэмж боловсруулсан ба шинээр боловсруулсан тайланг харах эрхийг даатгалын компанийн салбаруудын эрхийн тохиргоон дээр нэмж оруулсан.

2.8. МИД-ын 2015 оны борлуулалтын ажлын хүрээнд:

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн анхны борлуулалт, МИД-ын арав дахь борлуулалтын улирал 2015 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр 21 аймгийн нийт 330 суманд эхэлснээс хойш 2015 оны 7 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд оролцогч даатгагчид болох “Бодь даатгал” ХХК, “Монгол даатгал” ХХК, “Монре даатгал” ХХК, “МИГ даатгал” ХХК, “Практикал даатгал” ХХК, “Тэнгэр даатгал” ХХК-иуд нийт **10317 малчин** өрхийн 2.7 сая мал /27.7 тэрбум төгрөгийн хариуцлагатай/-ыг Малын индексжүүлсэн даатгал /МИД/-д хамруулан гэрээ байгуулж, **1 тэрбум 301 сая** төгрөгийн хураамж төвлөрүүлсэн байна. Даатгуулсан малчин өрх нь нийт малчин өрхийн 7.0 хувийг эзэлж байгаа бөгөөд өнгөрсөн онд даатгуулсан малчин өрхийн тооноос 3772 өрхөөр буюу 26.7 хувиар буурсан байна. Хэдийгээр даатгуулсан малчин өрхийн тоо буурсан боловч хураамжийн орлогын



бууралт нь даатгуулсан малчин өрхийн тооны бууралттай харьцуулбал бага байгаа нь малчид малаа илүү өндөр үнээр үнэлж даатгуулсан нь чанарын үзүүлэлт дээшилж байгааг харуулж байна.

2015 оны борлуулалтын улирлыг хааж, борлуулалтын мэдээллийн сан, орон нутгаас ирүүлсэн МИД-ын баталгааны 3-р хувийг хүлээн авч, борлуулалтын хаалтын бүртгэлийг оролцогч даатгалын компани тус бүртэй тулган баталгаажууллаа. 2015 оны МИД-ын борлуулалтын тайланг гарган Төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулж, холбогдох талуудад хүргүүллээ.

Оролцогч даатгалын компаниудын 2015 оны борлуулалтын багцаас хамааран бодит давхар даатгалын хураамжийн хэмжээг тооцоолж, тохируулгын гүйлгээг хийлээ. Хамтын эрсдэлийн санд 591.1 сая төгрөг, давхар даатгалын хураамжинд 348.4 сая төгрөгийн хураамжийг төвлөрүүлж холбогдох журмуудын дагуу арилжааны банкуудад байршуулсан.

ГУРАВ. БИЗНЕСИЙН ХӨГЖИЛ, ТӨСЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

3.1. Даатгалын зах зээлийн эрсдэлийн судалгаа болон хөдөө аж ахуйн даатгалын шинэ бүтээгдэхүүн боловсруулах, судалгааг хийх чиглэлээр:

Өнгөрсөн жилүүдэд хурдацтай өсч буй олон улсын давхар даатгалын хураамжийн тодорхой хэсгийг дотооддоо үлдээх зорилгоор Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Үндэсний давхар даатгалын компанийг үүсгэн байгуулах, эхлүүлэх бодлогын хүрээнд “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааны цар хүрээг өргөжүүлж, хөрөнгө оруулалтын сан, олон улсын хөрөнгө оруулагч нараас хөрөнгө татах замаар “Үндэсний давхар даатгал” ХК болон өргөжих талаар судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Улсын Их Хурлаас “Үрийн тариалангийн даатгалын тухай хууль”-ийг 1999 онд баталснаар даатгалын компаниуд үрийн тариалангийн талбайг албан журмаар даатгах эрх зүйн орчин бүрдсэн байдаг. Өнөөдрийн байдлаар үрийн тариалангийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байгаа бөгөөд энэхүү даатгалын бүтээгдэхүүнийг зах зээлд шинээр нэвтрүүлэх талаар холбогдох байгууллагуудтай урьдчилан тохиролцож санал солилцон, судалгааны ажил явуулж байна.

Компанийн цаашдын үйл ажиллагааны зорилтын хүрээнд тариалангийн салбарын хууль эрх зүйн орчин ямар байгаа, гадаадын ижил төстэй орнууд уг төрлийн даатгалыг яаж хийдэг, манай улсад нэвтрүүлэхэд тохиромжтой бүтээгдэхүүн, энэ төрлийн бизнес эрхлэгч этгээдүүдэд тохиолддог эрсдэлийн судалгаа зэргийг хийж шинэ бүтээгдэхүүний түвшинд санал боловсруулж, танилцуулга бэлтгэлээ.

Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Даатгагчдын Холбооноос газар тариалангийн даатгалын зөвшөөрөлтэй байгууллагуудын талаар мэдээлэл, тус



байгууллагуудын даатгалын гэрээ болон туршлагын талаар мэдээлэл авлаа. Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүнийг хариуцан ажиллаж байсан мэргэжилтнүүдтэй уулзаж, туршлагын болон давхар даатгалын гэрээний хэрэгжилтийн талаар мэдээлэл авсан.

ХБНГУ-ын нэр хүндтэй “Мюнх Рe” давхар даатгалын компанитай урьдчилсан байдлаар санал солилцон, зах зээлийн суурь мэдээлэл өгч, хамтын ажиллагааны талаар уулзалдсан болно. Мөн АНУ, ОХУ, Малави, Казахстан зэрэг улсын газар тариалангийн даатгалын тогтолцоо, алдаа, туршлагын талаар мэдээлэл цуглуулсан.

Үрийн тариалангийн даатгалын олон жилийн дадлага туршлагатай улс орнууд хэрхэн яаж эрсдэлийн менежментийг хийсэн түүх, арга барилын талаарх мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд Канад улсын туршлага, мэдээллийг авч бэлтгэсэн.

Үрийн тариалангийн даатгалын бүтээгдэхүүний нөхөн төлбөрийн тал дээр судалгаа хийх үүрэг чиглэлийн хүрээнд Финлянд улсын даатгалын нөхөн төлбөрийн арга туршлага, түүхийг судаллаа.

АНУ-ын Хөдөө Аж Ахуйн яам, Үр тарианы даатгалын компанийн үйл ажиллагаатай танилцах, хамтын ажиллагааны гэрээ байгуулах, Монгол улсад тариалангийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх зорилгоор Тариалангийн тухай хуулийн төслийн Ажлын хэсгийн ахлагч болох Улсын Их Хурлын Дэд дарга Л.Цог, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Энхтайван, Төслийн менежер нар АНУ-ын Вашингтон хотод 2015 оны 9 дүгээр сарын 18-ны өдрөөс 24-ний өдрүүдэд албан томилолтоор ажилласан.

Үрийн тариалангийн даатгалын шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэх талаар судалгааны ажлыг эхлүүлээд байгаа бөгөөд Тариалан эрхлэлтийг дэмжих сан, Хүнс, Хөдөө Аж Ахуйн яамны Стратеги бодлого төлөвлөлтийн газар, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын тариаланчдын холбоо, Монголын үр тариа эрхлэгчдийн “Газар тариалан” холбоо, “Монгол даатгал” ХХК, “Мандал генерал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Соёмбо даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК зэрэг байгууллагуудтай мэдээлэл солилцож, уулзалт, ярилцлага зохион явууллаа.

Үрийн тариалангийн даатгалын үйл ажиллагааг эхний ээлжинд хэрэгжүүлэх Булган, Сэлэнгэ, Төв аймгуудын сумдын сүүлийн 32 жилийн үрийн тариалан болон төмс хүнсний ногооны судалгааг авч нэгтгэсэн. Аймгуудын тариалангийн талаарх мэдээлэл цуглуулахад архив шатсан, хариуцсан ажилтан ажлаас гарсан, мэдээлэл хадгалсан хэрэгсэл вируст өртөн алга болсон гэх зэргээр мэдээлэл авахад хүндрэл учирч байсан болно.



Үр тариалангийн даатгалын асуудлаар Олон улсын зөвлөх хатагтай Олена Сосенкогийн газар тариалангийн даатгалын шинэ бүтээгдэхүүн гаргахад зөвлөгөө өгөх зорилгоор Монгол Улсын Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам, Цаг уурын газар, Монголын Тариаланчдын холбоо, “Мандал даатгал” ХХК, “Бодь даатгал” ХХК, “Миг даатгал” ХХК болон бусад байгууллага, салбарын төлөөлөгчидтэй хийх уулзалтыг зохион байгууллаа. Олон улсын зөвлөх хатагтай Олена Сосенкогийн Монгол Улсын газар тариалангийн даатгалын орчны талаар бичсэн тайлантай уншиж танилцан, уулзалтын тэмдэглэлтэй харьцуулан, нэмэлт саналаа хүргүүлсэн.

Япон Улсын ЖАЙКА-гийн байгууллагатай уулзалт зохион байгуулж, үр тарианы даатгалын бүтээгдэхүүнийг Монгол Улсад нэвтрүүлэх тал дээр дэмжлэг авах талаар хүсэлт гаргасан ба тус уулзалтын үр дүнд 2016 онд Монгол Улсад хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрт төслийн хүсэлтээ боловсруулан хүргүүлэхээр болсон.

Швейцарын хөгжлийн агентлагтай үр тарианы даатгалын бүтээгдэхүүн боловсруулах тал дээр дэмжлэг, туслалцаа үзүүлэх боломжтой эсэх талаар уулзалт зохион байгууллаа. Үр тарианы даатгалын асуудлаар олон улсын зөвлөх болон Газар тариалангийн холбооны тэргүүн Ч.Пэрэнлэйтэй хийсэн уулзалтад оролцлоо. Мөн “Монгол төмс хөтөлбөр”-ийн зохицуулагч Т.Төрмандахтай уулзалт зохион байгуулсан.

Монгол Улсын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яаман дээр 2015 оны 12 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монгол улс дахь хөдөө аж ахуйн тогтвортой хөгжил” ХБНГУ, Монгол улсын хамтарсан төслийн зөвлөгөөнд оролцов.

Эрчимжүүлсэн мал аж ахуйн даатгалын хэлбэрийг хөгжүүлэх, судлах зорилгоор хамаарах үхэр, гахай, тахианы фермийн талаарх мэдээллийг холбогдох байгууллагуудаас авч боловсруулан, урьдчилсан байдлаар даатгалын үнэлгээ болон хураамжийн тооцооллыг хийсэн. Мөн онцгой эрсдэлт түлш импортлогч, хадгалагч байгууллагын даатгуулдаг байгаль орчны хариуцлагын даатгалын бүтээгдэхүүний дотоодын зах зээлийн судалгааг хийх зорилгоор Газрын тосны газраас түлш, шатахуун импортоор оруулж ирж буй аж ахуй нэгж болон улсын хэмжээнд нийт хэдэн шатахуун түгээх станц үйл ажиллагаа явуулдаг гэх мэт асуудлаар мэдээллүүдийг хүсч, хариу авсан.

Тариалангийн даатгалын тухай хуулийг боловсруулах ажлын хэсэгт орж хамтарч ажиллахаар Хүнс Хөдөө Аж Ахуйн Яамтай ярьж зөвшилцсөн болно. “Олон эрсдэлт таримлын даатгалын бүтээгдэхүүний товч танилцуулга”-ыг бэлтгэлээ.

Олон улсын жишгээр газар тариалангийн даатгалыг хөгжүүлэхэд төрөөс газар тариалангийн талаар барьж буй бодлого, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь хамгийн чухал ажил байдаг. Газар тариалангийн салбарын ургац алдах эрсдэлийг дотоодын даатгалын зах зээлийн хөрөнгийн чадавхи,



санхүүгийн бололцоог ашиглан хаах боломжгүй гэдэг нь харагдаж буй тул гадаадын давхар даатгалын зах зээлд хандаж хамтран ажиллахыг зорьж байна. Энэ ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Ч.Сайханбилэг 2015 оны 7 дугаар сард ИБУИНВУ-д айлчлах үеэр “Ллойдс” компанийн захирал Жон Нэльсоныг хүлээн авч уулзан Монголын эдийн засгийн чухал ач холбогдол бүхий хөдөө аж ахуйн салбарыг ган, зуд зэрэг байгалийн гамшиг, эрсдэлээс хамгаалах чиглэлд хамтран ажиллах талаар судлахаар тохирсны дагуу “Ллойдс” компанийн Зүүн Өмнөд Азийн захирал ноён Кент Чаплинтай холбогдон өргөн хүрээнд хамтарч ажиллах бололцоог судалж байна.

3.2. Үйл ажиллагаа, бүтээгдэхүүнээ олон нийтэд сурталчлан таниулах, түгээх чиглэлээр:

2015 оны МИД-ын борлуулалтын үеэр сурталчилгаа хийх ажлын төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/22 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж ажиллалаа. Борлуулалтыг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын хүрээнд цаг тооны бичиг, МИД-ын товхимол, танилцуулга болон малчдад зориулсан сонинг хэвлүүлэн оролцогч даатгалын компаниуд, даатгалын төлөөлөгчдөөр дамжуулан олон нийтэд түгээлээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн танилцуулга, гарын авлагыг 20.0 мянган ширхэгийг хэвлэж оролцогч даатгалын компаниудад хүргүүллээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн цахим хуудсыг шинэчлэн, www.agreinsurance.mn цахим хуудас домайн нэр болон цахим хуудас байршуулах худалдан авалтыг 2014 оны 11 дүгээр сард хийсэн ба түүний загвар, хийц, агуулгын төслийг гаргаж 2014 оны 12 сард хийж дуусгасан. Цахим хуудас хөгжүүлэх сүүлийн үеийн арга технологиудыг судалж, хэрэглэгчийн интерфэйсийг Bootstrap framework, кодчилолын хэсгийг AngularJS, өгөгдлийн сантай ажиллах хэсгийг ASP.NET Web API ашиглаж хийх нь зүйтэй гэж сонгов. Цахим хуудасны нүүр хуудсыг боловсруулсан загварын дагуу хийж дуусгалаа. Цахим хуудсанд цаг үеийн мэдээг тухай бүр оруулан шинэчилж, компани болон үйл ажиллагааныхаа талаарх бүхий л мэдээллийг оруулж байна.

Малын индексжүүлсэн даатгалын тухай болон компанийн тухай мэдээллийг малчдад тухай бүр хүргэж, даатгалын ашиг тусыг сурталчлах, ойлгуулах зорилгоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нэртэй фэйсбүүк цахим хуудас нээн хөтлөх ажлыг эхлүүлсэн бөгөөд 21 аймгийн хамгийн олон хандалттай цахим хуудас хуудсуудтай хамтран ажиллах санал тавин, тодорхой хуудсууд дээр өөрсдийн мэдээллийг нийтэлж байна. Компанийн фэйсбүүк хуудаснаа “Мал маллах ухаан”, “Амьдралын зөв хэвшилд алхам алхамаар”, “Цаг агаарын мэдээ” зэрэг цуврал мэдээг тогтмол нийтэлж байна.

Малчдыг малаа МИД-д даатгуулахын ач тус, МИД төслийн үйл ажиллагааг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК үргэлжлүүлэн хэрэгжүүлж байгаа талаар 42



секунд, 48 секунд, 1 минут 28 секундийн 3-н шторкийг “EYESLENZ” студиэр бэлтгүүлэн хийлгэж 5 дугаар сарын 29-ний өдрөөс эхлэн “Малчин ТВ”-ээр тус бүр 2 удаагийн давтамжтайгаар өдөрт нийт 12 удаа, мөн 42 секунд, 48 секундын шторкыг МҮОНРТ-ээр 6 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 6 дугаар 30-ны өдөр хүртэл Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрийн өмнө өдөр бүр цацаж малчдын хүртээл болгов.

Эхний шторкоор “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК байгуулагдаж, малын индексжүүлсэн даатгал орон даяар үргэлжилж байгаа бөгөөд малчдын эрсдэлийг давхар даатгаж, найдвартай хариуцах эрх зүйн орчин бүрдсэн талаар харуулсан бол удаах шторкт малчдыг малаа даатгалд хамруулахыг уриалан, даатгалын борлуулалтын хугацаа 6 дугаар сарын 30-ны өдрийг хүртэл үргэлжлэхийг малчдад сануулсан.

Цагийн хүрд нэвтрүүлгээр нээлттэй хэлэлцүүлэгт компанийн ТУЗ-ийн гишүүн Л.Чой-Иш малын индексжүүлсэн даатгалын тухай ярилцлага өгсөн ба “Малчин ТВ” (“ROYAL TV”, “Seven TV”)-ээр 7 хоногийн мэдээний тоймд хамтран ажиллагч даатгалын компаниудын МИД хариуцсан ажилтнууд, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн Давхар даатгалын газрын дарга Т.Оюунбат нар МИД-ын тухай ярилцлага тус бүр 1 удаа өгсөн нэвтрүүлгийг давталттайгаар хүргэсэн.

“Ая дууны мэнд” нэвтрүүлгээр ТВ-ийн Notebook дээр малын индексжүүлсэн даатгалд хамрагдах уриа, компанийн логог байрлуулж байв. “Малчны хотонд” нэвтрүүлгээр малын даатгалд идэвхтэй хамрагддаг малчин Б.Анхбаярын гэрт очиж ярилцлага авч 5 дугаар сарын 26, 28-ны өдрүүдэд нэвтрүүллээ.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Энхтайван 2015 оны 6 дугаар сарын 20-ны өдөр, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтан М.Мөнхсүвд 6 дугаар сарын 24-ний өдөр, Ц.Мандах-Эрдэнэ 6 дугаар сарын 27-ны өдөр тус тус “Малчин” телевизийн зочны ярилцлагад оролцож “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн талаар болон МИД-ын талаар 20 минутын ярилцлага өгч малчдад мэдээлэл, ойлголт өгч ажиллав.

Мөн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн ажилтан Ц.Мандах-Эрдэнэ 2015 оны 6 дугаар сарын 21-ний өдөр, Давхар даатгалын газрын дарга Т.Оюунбат 6 дугаар сарын 26-ны өдөр тус тус МҮОНРТ-ийн “Хурд” мэдээллийн агентлагийн бэлтгэн явуулдаг 10 минутын радиогийн нэвтрүүлэгт оролцож, малын индексжүүлсэн даатгалын тухай мэдээллийг малчдад хүргэсэн ба эдгээр нэвтрүүлгийн дундуур компанийн бэлдсэн шторк, малчдаас авсан богино хэмжээний ярилцлагуудыг давталттайгаар малчдад хүргэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос “Дунд түвшиний алдагдлаас хамгаалах сангийн тухай журам” боловсруулсны дагуу дунд түвшиний алдагдлаас хамгаалах сангийн тооцооллыг хийж, гүйцэтгэх удирдлагад танилцууллаа.



Хөдөө орон нутгийн удирдлагууд болон малчин иргэдэд компанийхаа үйл ажиллагааг сурталчлан таниулах зорилгоор 2015 оны 6 дугаар сарын 08-ны өдрөөс 19-ний өдрийг хүртэлх томилолтын тайланг бичиж, удирдлагуудад танилцуулан хөдөө орон нутгийн томилолтын тайлангуудыг нэгтгэн гаргалаа.

МИД-ын гарын авлага болон бусад танилцуулга, “МИД-ын хураамжийн хэмжээг тооцох журам”, “МИД-ын хамтын эрсдэлийн сангийн хөрөнгө, түүнийг санхүүжүүлэх, зарцуулах журам”, “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”, “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн үйл ажиллагааны тайлан, Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн боловсруулах ажлын хүрээнд олон улсын зөвлөх Олена Сосенкогоос “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д ирүүлсэн даатгалын бүтээгдэхүүний гэрээ, Үрийн буудайн даатгалын бүтээгдэхүүний танилцуулга, Газар тариалангийн даатгалын бүтээгдэхүүн Монгол Улсын газар тариаланд нэвтрүүлэх ажлын хүрээнд үр тариа болон төмс, хүнсний ногооны сум болон аймгаар гаргасан түүхэн мэдээлэл, АНУ-ын холбооны үрийн тариалангийн даатгалын хөтөлбөрийн тухай танилцуулга зэргийг англи хэлнээ орчуулсан.

Давхар даатгалын газрын ажилтнууд олон нийтийн “Эх орон” телевизтэй хамт Архангай аймагт албан томилолтоор ажиллаж, нөхөн төлбөрийг малчдад олгож байгаа тухай бэлдсэн мэдээг youtube.com болон компанийн “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нэртэй фэйсбүүк цахим хуудас дээр тус тус байршууллаа.

ДӨРӨВ. ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, НӨХӨН ТӨЛБӨРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

4.1. Компанийн сангийн хөрөнгийг удирдах, хөрөнгө оруулалтыг зохион байгуулах чиглэлээр:

Бондын гэрээний хэрэгжилтэнд хяналт тавьж, хүүгийн өгөөжийн тооцооллыг хийв. “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн өөрийн хөрөнгө болох 15.0 тэрбум төгрөгийн 14.7 тэрбум төгрөгт компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 02/06 дугаар тогтоолын дагуу 16.074 хувийн хүүтэй, 364 хоногийн хугацаатай /2014.10.13-2015.10.12/ 17,000 мянган ширхэг Засгийн газрын үнэт цаасыг шууд оролцогчоор дамжуулан худалдан авсан ба энэхүү үнэт цааснаас тайлант хугацаанд 1,838,885,675 /нэг тэрбум найман зуун гучин найман сая найман зуун наян таван мянга зургаан зуун далан таван/ төгрөгийн өгөөж хүртсэн.

Дээрх худалдан авсан Засгийн газрын үнэт цаасны хугацаа 2015 оны 10 дугаар сарын 12-ны өдөр дуусгавар болсон тул компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 02/30 дугаар тогтоолын дагуу Монголын хөрөнгийн биржийн ээлжит арилжаагаар 2,475,591,492 /хоёр тэрбум дөрвөн зуун далан таван сая таван зуун ерэн нэгэн мянга дөрвөн зуун ерэн хоёр/ төгрөгт 15.0 хувийн хүүтэй, 364 хоногийн хугацаатай /2015.10.27-2015.10.26/ 28,459 ширхэг Засгийн газрын үнэт



цаасыг хамгийн бага арилжааны шимтгэлийн санал ирүүлсэн брокер диллерийн “Новел Инвестмент” ХХК, “Гүүдсек” ХХК-иар дамжуулан худалдан авсан ба тайлант хугацаанд 66,729,190 /жаран зургаан сая долоон зуун хорин есөн мянга нэг зуун ерэн/ төгрөгийн өгөөжийн орлогыг орууллаа.

Мөн Төрийн банк /шууд оролцогч/-аар дамжуулан 2015 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 14,523,348,686 /арван дөрвөн тэрбум таван зуун хорин гурван сая гурван зуун дөчин найман мянга зургаан зуун наян зургаан/ төгрөгт 14.8 хувийн хүүтэй, 364 хоногийн хугацаатай 16,665 ширхэг Засгийн газрын үнэт цаас худалдан авч тайлант хугацаанд 310,407,858 /гурван зуун арван сая дөрвөн зуун долоон мянга найман зуун тавин найман/ төгрөгийн өгөөжийн орлого олсон.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК нь 2015 онд Засгийн газрын үнэт цааснаас нийт **2,216,022,723 /хоёр тэрбум хоёр зуун арван зургаан сая хорин хоёр мянга долоон зуун хорин гурав/** төгрөгийн өгөөжийн орлогыг бүрдүүлсэн байна.

“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-ийн алдагдлаас хамгаалах сангийн 15.0 тэрбум төгрөг нь 2014-2016 онуудад 3 хуваагдан шилжиж ирэх бөгөөд одоогийн байдлаар 7.0 тэрбум төгрөг улсын төсвөөс компанийн дансанд шилжиж ирсэн.

Алдагдлаас хамгаалах сангийн 2014 оны эхний 5.0 тэрбум төгрөгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-д заасны дагуу банкуудаас хадгаламжийн хүүгийн санал авч компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 1 дүгээр сарын 07-ны өдрийн 02/08 дугаар тогтоолын дагуу дараах байдлаар байршуулав.

- Төрийн банкинд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 16.2 хувийн хүүтэйгээр;
- ХААН банкинд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 16.5 хувийн хүүтэйгээр;
- Худалдаа хөгжлийн банкинд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 14.4 хувийн хүүтэйгээр;
- Хас банкинд 1.25 тэрбум төгрөгийг жилийн 16.3 хувийн хүүтэйгээр тус тус 4 банкинд тэнцүү хувааж, хүүг нь сар бүр үйл ажиллагааны зардлын дансанд шилжүүлэх нөхцөлтэйгээр нэг жилийн хугацаатайгаар байршууллаа.

Мөн Алдагдлаас хамгаалах сангийн 2015 оны санхүүжилтийн 2.0 тэрбум төгрөгийг хадгаламж хэлбэрээр байршуулахаар арилжааны 13 банкинд 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 03/25 дугаартай албан бичгийг хүргүүлэн, банкуудын ирүүлсэн хүүгийн саналыг нэгтгэж, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд танилцуулж саналыг авсны дагуу дараах байдлаар байршууллаа.

- Төрийн банкинд 1.0 тэрбум төгрөгийг жилийн 16.2 хувийн хүүтэйгээр;



- ХААН банкинд 1.0 тэрбум төгрөгийг жилийн 16.5 хувийн хүүтэйгээр тус тус нэг жилийн хугацаатай гэрээ байгуулан байршууллаа.

МИД-ын дээд түвшиний давхар даатгалын хураамжийн хөрөнгө болох 446,500,000 /дөрвөн зуун дөчин зургаан сая таван зуун мянган/ төгрөгийг 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Голомт банкинд жилийн 16.8 хувийн хүүтэйгээр 9 сарын хугацаатай байршуулж тайлант хугацаанд 8,837,030 /найман сая найман зуун гучин долоон мянга гучин/ төгрөгийн хүүгийн орлогыг оруулав.

Нийт хадгаламжийн хүүгийн орлого 2015 оны жилийн эцсийн байдлаар 1,004,566,131 /нэг тэрбум дөрвөн сая таван зуун жаран зургаан мянга нэг зуун гучин нэгэн/ төгрөгийн хүүгийн орлого оруулахаар тооцсоноос **972,095,859 /есөн зуун далан хоёр сая ерэн таван мянга найман зуун тавин есөн/** төгрөгийн хүүгийн орлого оруулсан байна. Зөрүү 32,572,936 /гучин хоёр сая таван зуун далан хоёр мянга есөн зуун гучин зургаан/ төгрөг нь гэрээний дагуу 2016 оны 1 дүгээр сарын 01-нд харилцах дансанд шилжин орж ирнэ.

Банкуудад байршуулсан хадгаламжийн хүүгийн орлогуудыг Төрийн банкны харилцах дансанд нэгтгэн байршуулсан ба давхар даатгалын хураамжийн орлогыг Голомт банкинд байршуулснаас нийт харилцахын хүүгийн орлого 139,405,737 /нэг зуун гучин есөн сая дөрвөн зуун таван мянга долоон зуун гучин долоон/ төгрөгийг орууллаа.

Харилцах данс болон хадгаламжийн нийт хүүгийн орлогод 2015 онд **1,111,501,596 /нэг тэрбум нэг зуун арван нэгэн сая таван зуун нэг мянга таван зуун ерэн зургаан/** төгрөгийн хүүгийн орлого оруулж, сангийн хөрөнгийг өсгөн нэмэгдүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулсан “Хөдөө аж ахуйн давхар даатгалын нөөц санг бүрдүүлэх зарцуулах, хяналт тавих журам”-ын төсөлтэй танилцаад, санал боловсруулан хүргүүлж холбогдох албан тушаалтнуудтай уулзалт зохион байгууллаа.

Бонд болон хадгаламж байршуулах журмын төслийн нийтлэг үндэслэл, хөрөнгийн эх үүсвэр зэрэг бүлгүүдийг боловсруулан удирдлагад танилцуулав.

Санхүүгийн хямралын нөлөөгөөр хөрөнгийн зах зээлийн гол үзүүлэлтүүд буурч, зогсонги байдалд ороод байгаа өнөө үед хөрөнгө оруулалт хийх сувгийг нэмэгдүүлэх судалгааг хийв. Үүнд:

1. Хадгаламжийн сертификатыг Банкны хадгаламжтай
2. Банк бус санхүүгийн байгууллагын Итгэлцлийн үйлчилгээг Банкны хадгаламжтай тус тус харьцуулан хийлээ. Хадгаламжийн сертификат, Банк бус санхүүгийн байгууллагын Итгэлцлийн үйлчилгээ нь өөр өөрийн давуу талуудтай боловч сул талууд ихтэй бөгөөд тус компанийн хувьд банкны хадгаламж нь илүү тохиромжтой болохыг дүгнэлтээр нотоллоо.



Монголын Хөрөнгийн Бирж болон Монгол Банкаар дамжуулан Засгийн Газрын үнэт цаас худалдан авах талаар харьцуулсан судалгаа хийлээ. Судалгаагаар Монгол Банкаар дамжуулан Засгийн Газрын үнэт цаас худалдан авах нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан авахаас шимтгэлийн хувьд бага байлаа.

2014 оны борлуулалтын нөхөн төлбөрийн тооцоолол, олголттой танилцаж судалгаа хийв. 2014 оны борлуулалтын нөхөн төлбөрт 7 аймгийн **1291** малчин өрхөд **62,846,217 /жаран хоёр сая найман зуун дөчин зургаан мянга хоёр зуун арван долоон/** төгрөгийн нөхөн төлбөр олгогдох тооцоо гарсан байна. Өвөрхангай, Өмнөговь, Төв аймгуудад анх удаа нөхөн төлбөрийн тохиолдол гарч байгаа бөгөөд Баянхонгор аймагт хамгийн их 48,911,456 /дөчин найман сая есөн зуун арван нэгэн мянга дөрвөн зуун тавин зургаан/ төгрөгийн нөхөн төлбөр гарсан.

2015 оны хувьд **10317 /арван мянга гурван зуун арван долоо/** малчин өрх даатгуулан **1 тэрбум 301 сая** төгрөгийн даатгалын хураамж авсан байна.

Хөрөнгийн удирдлага нөхөн төлбөрийн газрын 2016 оны төсөв, мэргэжлийн холбогдолтой ном, гадаад сэтгүүл болон сургалтын танилцуулга хийсэн.

Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөөний бизнесийн орчны шинжилгээ, зах зээлийн нөхцөл, төлөв байдал, санхүүгийн болон зах зээлийн эрсдэл, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний талаар судалгаа хийж бизнес төлөвлөгөөнд орууллаа. Хамтын тэтгэврийн сангийн талаар судалгаа хийж бизнес төлөвлөгөөнд тусгасан.

Хөрөнгө оруулалтын шинэ сувгийн судалгаа хийж, хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалтын менежментийн компаниар хөрөнгөө удирдуулах боломжийн талаар судалгааг эхлүүлсэн.

4.2. Бусад ажлын чиглэлээр:

Гүйцэтгэх захирлын 2015 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн 04/49 дугаар тушаал болон шалгалтын удирдамжийн дагуу Хөрөнгийн удирдлага, нөхөн төлбөрийн газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг 2015 оны 8 дугаар сарын 05-ны өдрөөс 15-ны өдрүүдэд Компанийн 2014 оны 4 дүгээр улирал, 2015 оны 1, 2 дугаар улирлын санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдэл, компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж гүйцэтгэлээ. Шалгалтыг хийж гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, шалгалт хийх удирдамжийн дагуу ажиллаж цаашид авах арга хэмжээ, санал, зөвлөмжийг боловсрууллаа.

МИД болон даатгалын нөхөн төлбөр, сангуудын талаар ерөнхий ойлголт өгч ажилчдын чадавхийг бэхжүүлэх сургалтанд оролцож, Дэлхийн банкны зөвлөхүүдийн явуулсан эрсдэл тооцох загварын сургалтанд хамрагдсан.



ТАВ. САНХҮҮ, УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР

5.1. Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх талаар:

Гүйцэтгэх захирлын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 04/13 дугаар тушаалаар компанийн үйл ажиллагаанд мөрдөгдөх журмын төсөл боловсруулах, батлуулах, Санхүүгийн зохицуулах хорооноос батлах зарим журмын төсөлд санал өгөх, санаачлах, МИД-ын 2015 оны борлуулалтын улиралд хийгдэх ажлын жагсаалтыг баталж хэрэгжүүлэн ажиллалаа.

Өдөр тутмын үйл ажиллагаандаа Гүйцэтгэх захирлын 2015 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 04/12 дугаар тушаалаар батлагдсан компанийн хөдөлмөрийн дотоод журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд компанийн хувийн хэрэгт байвал зохих баримт бичгийн жагсаалт гарган баримт бичиг нэг бүрийн бүртгэл хөтлөх, хадгалах албан тушаалтнуудыг үүрэгжүүлэн ажиллуулж байна.

Компанийн санхүүгийн төлөвлөгөө, Бизнес төлөвлөгөөг батлах, ажлын тайлан танилцуулах болон бусад асуудалтай холбоотой тооцоо, судалгаа, санал, ажлын тайлан зэргийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарах тогтоолын төслийн хамт бэлтгэн удирдлагуудаар хянуулж, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд хүргүүлэн танилцуулах зэргээр Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг цаг тухай бүрд нь хангаж ажиллалаа.

Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг газар тус бүрээр гарган танилцуулав.

Албан бичиг хэргийн стандартыг мөрдөж ажиллах, байгууллагын албан бичиг боловсруулалтыг сайжруулах зорилгоор дараах зарчмыг баримтлан хэвшүүлж байна. Үүнд: Гүйцэтгэх захирлын тушаал, албан бичгийг боловсруулсан ажилтан боловсруулсан бичгээ Газрын дарга, Ерөнхий хуульч, Гүйцэтгэх захирлын орлогч, Гүйцэтгэх захирал гэсэн дарааллаар танилцуулж хянуулаад зөвхөн Захиргааны ажилтан хэвлэмэл хуудсан дээр гаргаж байх;

Байгууллагын албан бичгийн боловсруулалтын дардас хийлгэн архивт үлдэх хувийн ар талд дарж баталгаажуулдаг боллоо. Гүйцэтгэх захирлын тушаал, ирсэн, явсан бичгийн бүртгэлийг хавтасаар болон цахим хэлбэрээр хөтөлж байна. Мөн удирдлагуудад зориулсан албан бичгийн дундын сан, нийт ажилтнуудад зориулсан албан бичгийн дундын санг бий болгон холбогдох албан бичгүүдийг тавьж танилцуулж байна.

Удирдлагатай хийх уулзалтын хүсэлтийг цаг тухай бүрт нь хүлээн авч зохион байгуулж байна. 7 хоног бүрийн Даваа гарагт болдог Шуурхай хуралдааны



тэмдэглэл хөтөлж, өгөгдсөн үүрэг даалгаврын жагсаалтыг хүснэгтээр гарган холбогдох албан тушаалтнуудад хүргүүлж, биелэлтийг нь дараагийн шуурхайгийн өмнө удирдлагад танилцуулдаг. Мөн удирдлагуудын болон компанийн ажилтнуудын албан томилолтоор явах зардлын тооцоог хийж, хөтөлбөр, явах чиглэл, хуваарийг гарган батлуулж ажиллалаа. Шуурхай хуралдааны мэдээллийг албан бичгийн сангийн дундын сангаар ажилтнуудад мэдээлж байна.

2015 онд компанийн хэмжээнд дагаж мөрдөх дүрэм, журам, заавар, ажлын төлөвлөгөө батлахтай холбоотой 9, хөрөнгө зарцуулахтай холбоотой 29, албан тушаалтан томилохтой холбоотой 32, бусад чиглэлээр 16, нийт 86 Гүйцэтгэх захирлын тушаал батлагдаж, үйл ажиллагааны чиглэлийн хүрээнд 223 албан бичгийг боловсруулан гаргасан байна.

Тайлант хугацаанд 25 ажилтантай хөдөлмөрийн гэрээ байгуулан, ажилтан тус бүр дээр хувийн хэрэг нээн хөтөлж, ажилтнуудад ажлын үнэмлэх, нэрийн хуудсыг загвар гарган хэвлүүлж өглөө. Мөн компанийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулан Ерөнхий хуульчаар хянуулж, Гүйцэтгэх захирлаар батлуулав.

“Компанийн ажилтнуудын ёс зүйн дүрэм”, “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам” зэргийг нийт ажилтнуудын саналыг авч боловсруулан Гүйцэтгэх захирлын тушаалаар баталлаа. Ажилтнуудын саналыг авч хэлэлцэн компанийн Ёс зүйн хороог 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан ажиллуулж байна.

Цагийн бүртгэлийг тогтмол хөтөлж, сарын цалинг бодохдоо тооцож байна. Ажлын цагийн цахим бүртгэлийн тоног төхөөрөмж, программыг худалдан авч ашиглаж байна.

Гүйцэтгэх захирлын “Байгууллагын дотоод журмыг мөрдөж хэвшүүлэх тухай” 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 04/39 дугаар тушаалыг хэрэгжүүлэх талаар ажилтнуудад мэдээлэл хүргэж, биелэлтийг нь 7 хоног бүр шуурхай хурлын тайланд мэдээлж байна. Компанийн хөдөлмөрийн дотоод журмын 2.3.5 дахь заалтын хүрээнд ажилтан бүр 7 хоногийн ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Компанийн Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө оруулгын мэдүүлгийг гаргаж өгөх албан тушаалтнуудын жагсаалтыг баталж холбогдох хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, ХАСХОМ-ийг бүртгэх, хадгалах болон Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх эрх бүхий албан тушаалтныг томилон ажиллуулж байна.

Тус компанийн банкинд байршиж буй нөөц сангийн талаар танилцуулга боловсруулан, тухайн банкуудад ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажиллах саналыг хүргүүлээ. Энэ ажлын хүрээнд Төрийн банкны



ШУТИС салбарын удирдлага, эдийн засагч нар ирж компанийн ажилтнуудад мэдээлэл өгсөн.

Ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах зорилгоор “Сонгдо”, “Гурван гал”, “Интермед”, “Грандмед”, 1-р эмнэлэг, 3-р эмнэлэгүүдийн багцыг судлан Нэгдсэн 1-р эмнэлэг, 3-р эмнэлэг зэргийг сонгон гэрээ байгуулан үзлэгт хамруулсан. Нэгдүгээр ээлжийн 10 ажилтныг 8 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд 1-р эмнэлэгт, хоёрдугаар ээлжийн 15 ажилтныг 10 дугаар сард 3-р эмнэлэгт үзлэгт хамрууллаа.

Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх асуудлыг “Голден Жем” фитнесстэй гэрээ хийн эрх авч хичээллэх, “Өсвөрийн Зохион Бүтээгч” лаборатори сургуультай биеийн тамирын заалыг нь 2015 он дуустал ашиглах гэрээ байгуулан хичээллэх зэргээр шийдвэрлэн ажиллалаа.

5.2. Компанийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд 1,111.5 сая төгрөгийн хүүгийн орлого, 446.5 сая төгрөгийн давхар даатгалын орлогод тооцсон хураамж, нийт 1,558.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үйл ажиллагааны зардалд 956.8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардалд 391.1 сая төгрөг зарцуулсан байна.

2014 оны санхүүгийн тайланд 2015 оны 3 дугаар сарын 13-ны өдрөөс 20-ны өдрүүдэд “Алаг уул аудит” ХХК-аар иж бүрэн аудит хийлгэсэн ба аудитлагдсан тайланг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж холбогдох хууль, журмын дагуу тогтоосон хугацаанд Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо болон Сүхбаатар дүүргийн санхүү, төрийн сан, татварын хэлтэст хүргүүлээ.

Улирал бүр санхүүгийн тайланг бэлтгэн Сүхбаатар дүүргийн санхүүгийн хэлтэс, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн ба 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг хуулинд заасан хугацаанд Сангийн яамны НББ-ийн болон Санхүүжилт тайлан бүртгэлийн хэлтэст тус тус хүргүүлсэн байна.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан Сангийн яамны НББ-ийн бодлогын газарт санал авахаар хүргүүлээ.

Компанийн үйл ажиллагааны зардлын холбогдох тооцооллыг цаг тухай бүрт нь хийж, цалин, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг шилжүүлэн, нийгмийн даатгалын шимтгэлийн тайланг бэлтгэн цахимаар болон цаасаар илгээж, ажилтнуудын нийгмийн даатгалын дэвтрийн баталгаажилтыг хийлгэсэн.

Сангийн яамны 2015 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн А/99 тоот тушаалаар МИД төслийн үйл ажиллагаа, эд хөрөнгийг “Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХК-д шилжүүлэх Ажлын хэсэг байгуулагдаж Дэлхийн банкны Ажлын



хэсгийн тайланд нэмэлт өөрчлөлт оруулан Дэлхийн банкинд хүргүүлсэн ба Дэлхийн банкнаас өгсөн чиглэлийн дагуу шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд МИД төслөөс 6 ажилтан, 1 сервер, бусад эд хөрөнгийг тус компанид шилжүүлэн авлаа.

Компанийн вэб сайт дээр 2014 оны санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, 2015 оны төсөв, худалдан авах ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөө, 2015 оны хагас жилийн төсвийн гүйцэтгэл, 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан зэргийг байршууллаа. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй худалдан авалт, цалингаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг Шилэн дансны тухай хуулийн хүрээнд байршуулж байна.

2016 оны компанийн Бизнес төлөвлөгөө, төсөв, худалдан авалтын төлөвлөгөөг газар, нэгж тус бүрээр гаргуулан нэгтгэж бэлэн болгон 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав.

“Ординат” ХХК-тай гэрээ байгуулан “Юникус” нэртэй санхүү, цагийн бүртгэлийн программыг худалдан авалтыг хийлээ. Программын тохируулгыг хийснээр ажилд бэлэн болголоо.

Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/49 дугаар тушаалаар байгуулагдсан Дотоод хяналтын ажлын хэсэг компанийн эхний хагас жилийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт бичгийн бүрдэл болон ажлын төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийсэн. Ажлын хэсгийн дүгнэлтэнд тулгуурлан баримт, бичгийг эмхлэх цэгцлэх ажлыг гүйцэтгэлээ.

2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс 11 дүгээр сарын 1-ний өдрийн хооронд даатгагчдын холбооны спортын арга хэмжээнд амжилттай оролцсон. Шатрын төрөлд 2 хүрэл, гар бөмбөгийн холимог төрөлд хэсгээсээ шалгарсан амжилт гаргалаа.

5.3. Эд хөрөнгийн худалдан авалт, хадгалалт, хамгаалалт, бүртгэлтэй холбоотой ажлын чиглэлээр:

2015 оны худалдан авалтын төлөвлөгөөний дагуу 306.5 сая төгрөгийн бараа, 10.1 сая төгрөгийн ажил, 78.6 сая төгрөгийн үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэлээ.

Орлого зарлагын баримт болон шаардах хуудас кассын орлого, зарлагын баримтыг 1, 2-р гарын үсэгтэй зөвшөөрлийн дагуу бараа материал эд зүйлсийг тавьж олгож байна. Хөдөө орон нутагт ажиллах компанийн ажилтнуудад зориулсан замын унаад суусан бичиг, жолооч нарт зориулсан жолоочийн тооцооны хуудасны загваруудыг гаргалаа.



Өмч хамгаалах зөвлөл байгуулах, компанийн эд хөрөнгийн тооллого явуулах бүрэлдэхүүнийг Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/50 дугаар тушаалаар байгуулсан. Эд хөрөнгийн тооллогыг 2015 оны 8 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд явууллаа. Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалт, хөдөлгөөн, өөрчлөлтийг журмын дагуу хийж гүйцэтгэв. Компанийн эд хөрөнгө, компьютер, техник тоног төхөөрөмжийг хүн нэг бүр дээр бүртгэлийн карт нээн хөтөлж хүлээлгэн өгсөн.

Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдсан 5 ажилтан 2015 оны 8 дугаар сарын 13-нд шалгалтанд хамрагдан тэнцэж тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо байгуулах бүрэлдэхүүн бэлэн болов.

Гүйцэтгэх захирлын 2015 оны 04/54 дугаар тушаалаар байгуулагдсан Бартаат зам туулах чадвартай суудлын автомашин худалдан авах тендер шалгаруулалтын Үнэлгээний хороо тендерийн бичиг баримтыг боловсруулах, тендерийн зарыг үндэсний өдөр тутмын сонинд тавихаас гэрээ байгуулах хүртэлх тендер шалгаруулалтын бүхий л үйл ажиллагааг амжилттай зохион явууллаа. Үнэлгээний хорооны хурлыг 2015 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр хийж Бартаат зам туулах чадвартай суудлын автомашин нийлүүлэгчээр “Таван Богд” ХХК шалгарч, худалдан авалтыг хийлээ.

Компанийн үйл ажиллагааг тогтворжуулах зорилгоор 186 м2 талбай бүхий ажлын байрыг түрээслэх, албан хэрэгцээний суудлын автомашин, компьютер, техник хэрэгсэл, ширээ сандал худалдан авах, интернет сүлжээнд холбогдох зэрэг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгууллаа.

5.4. Компанийн компьютер, техник, тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагааг хангах чиглэлээр:

Компанийн цахим хуудасны холболтыг Сангийн яамны цахим хуудсанд байршуулах, Шилэн дансны мэдээллийг оруулах хэрэглэгчийн эрхийг үүсгэх, шилэн дансны мэдээллийг холбогдох хууль журмын дагуу хугацаанд нь тогтмол шинэчлэн оруулах, ажилтнуудын компьютерыг дотоод сүлжээнд холбох, Төсөл хэрэгжүүлэх нэгжээс ирсэн сервер компьютерыг ажилд бэлтгэж өгөгдлийн сан болон программын хэсгийг тусад нь салгаж виртуал сервер үүсгэн байрлуулах, ажлын хэвлэгчийг сүлжээний орчинд ажилладаг хэвлэгчээр сольж ажилд бэлтгэх, дотоод болон гадаад сүлжээнд гарсан доголдлын шалтгааныг тогтоох, ажилтнуудын компьютерт антивирусийн программ, ажлын программ, дотоод сүлжээний мессенжер, и-мэйлийн программ зэрэг хэрэгцээт программуудыг суулган тохируулж өгөх зэргээр хэвийн ажиллагааг хангалаа. Мөн дундын сангийн серверийг ажилд бэлтгэн хэрэглэгчид болон хэрэглэгчийн эрхийн тохиргоо, хавтаснуудын тохиргоог үүсгэж ажилчдын компьютерт тохируулж өгсөн.



Дотоод файлын серверийн антивирусийн эсрэг программын хугацаа дууссан байсныг сунгасан. Байгууллагад ашиглаж байгаа хэрэгцээт программуудын албан ёсны лиценз худалдаж авах ажлын хүрээнд үнийн судалгаа хийж албан ёсны зөвшөөрөлтэй компаниас үнийн санал авав.

5.5. Уулзалт, сургалт, зөвлөгөөн зохион байгуулах, ажилтнуудаа чадавхжуулах чиглэлээр:

Компанийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтыг 2015 оны 4 дүгээр сарын 18-нд Санхүүгийн зохицуулах хороо, МИД төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран зохион байгуулж сургалтанд нийт 22 ажилтан бусад этгээд хамрагдсан байна.

“Худалдан авах ажиллагааны онолын үндэс, олон улсын туршлага, эрх зүйн орчин” сэдэвт сургалтанд 5 хүн, Компанийн нягтлан бодогч 5 дугаар сарын 22-нд Төрийн банкнаас зохион явуулсан “Бүтээлч сэтгэлгээ ба хэлэлцээр хийх ур чадвар” сургалтанд тус тус хамрагдав.

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам, Ёс зүйн дүрэм зэрэг шинээр батлагдсан дүрэм, журмуудыг танилцуулах зорилгоор компанийн ажилтнуудын дунд 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдөр сургалт, семинар зохион байгууллаа. Сургалт, семинарын дараа ажилтнуудын идэвхтэй амралтын хүрээнд олон талт арга хэмжээг зохион явууллаа.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН ДАВХАР ДААТГАЛ” ХК
14210, Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энх тайваны өргөн чөлөө-23,
“UBH center”, 14 давхар, 1406 тоот
Э-шуудан: info@agreinsurance.mn
Вэб: www.agreinsurance.mn
Утас: 75770002
Факс: 75770003

----- о О о -----